

БАТЛАВ.

ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ө.ЦЭВЭЭНСҮРЭН  
МАТАД СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН 2023-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН  
4 ДҮГЭЭР АНГИЙН МОНГОЛ ХЭЛ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ

Сурагчийн ..... овог .....нэр  
..... он ..... сар .....өдөр “А” ХУВИЛБАР

ХУГАЦАА: 40 МИН: НИЙТ 24 ОНОО

НЭГ: УНШИХ ЧАДВАРЫН ДААЛГАВАР Санамж:1.Эхийг анхааралтай давтан уншиж ойлгосны дараа даалгаврыг гүйцэтгээрэй.

2.Сонгох даалгаврын зөвхөн нэг л хувилбарыг сонгоорой.  
Сонгох хариутай даалгавар бүр 1 оноотой

Эхийн хайр

Эхийн хайр Бага насны минь дутуу гацуу борогхон амьдрал минь... Ухаан орсон цагаас минь л миний дэргэд аав аа гэж дуудах хүн байсангүй. Дандаа л ээж, ээж, бас дахин ээж... Ээж ажилдаа явна. Ээж хоолоо хийнэ. Ээж гэрээ цэвэрлэнэ. Бүгдийг л ээж минь амжуулдаг байж. Харин сургуулийн биеийн тамирын арга хэмжээ, тэмцээн уралдаан, эцэг эхийн хурал болоход ээж минь ирдэггүй байлаа. Үнэндээ хоёр биенээ тэжээх гэж зүтгэж ажиллаж байсан ээжид минь сургууль дээр ирэх зав байдаггүй байлаа. Ажил .... ажил... ажил...Ийм л амьдралд өсчээ би.

15 нас хүрэх жил юм даг. Анх удаа ээжээсээ төрсөн өдрийн бэлэг авлаа. Дулаахан бор өнгийн ноосон цамц.Ээжээсээ бэлэг авна гэдэг хичнээн сайхан ч дотроо би ээжийгээ ихэд өрөвдөж байлаа. "Ээж минь цамц надад авч байхын оронд энэ мөнгөөрөө хиймэл шүдээ хийлгэхгүй дээ..." гэж бодож байв. Өөртөө биш үр хүүхдэдээ бүхнийг зориулдаг эх хүн гэдэг агуу. Гар нь хатууран эвэршээд нүүрэндээ ямар ч оо энгэсэг түрхээгүй ээж минь миний төлөө хичнээн зүтгэж ажиллаж байгааг ойлгодоггүй байж дээ.

Сургийн альбом дээрх залуу насны ээжийн минь ганган зураг үнэхээр л түүх болон үлджээ. Цав цагаан шүдээ яралзуулан инээх ээжийн минь залуу нас гангар шаазан шиг хэврэгхэн бас богинохон байж. Дэрвэлзэж явсан залуу насаа орхиж дэндүү жаахан үрийнхээ төлөө зүтгэхээр эвэршсэн гар, энгэсэггүй царайг сонгожээ ээж минь. Өөрийн эрхгүй нулимс гарч байлаа.

Удалгүй ахлах сургуулиа төгслөө. Энэ үед дэвшин суралцах сургуулийн тухай хурал болоход ээж маань анх удаа гараа өргөн босч "Их сургуульд хэдэн төгрөг зарцуулах бол..." гэж асууж билээ.Их сургуульд явах ямар ч бололцоогүйг минь мэдсээр байж, яагаад... гэж бодон гайхан ээж рүүгээ харахад ээж минь гэртээ хариад надад хадгаламжийн дэвтэр үзүүлээ.

Их сургуульд сурах 4 жилийн зардлыг ээж минь цуглуулсан байлаа. Өөрийгөө гаргуунд нь хаян байж ажиллаж байсан ээжээрээ бахархаад баршгүй.Нутгаасаа хол сургуульд явах үед ээж минь нүд дүүрэн нулимстай инээвхийлэн "Миний хүү хичээгээрэй. Ээжийнх нь санаа одоо л нэг амарч байна. Энэ ороолтыг ээжийгээ санасан үедээ зүүгээрэй" хэмээн хэзээ ч юм бас л гараараа нэхсэн улаан ноосон хүзүүний ороолт надад зүүлгэж билээ. Их сургуулийн 4 жилийг ээжийнхээ өгсөн бор ноосон цамц, улаан ороолтоор чимэн амжилттай төгсөв. Амьдралын баяр баясгалантай үед ч, уйтгар гунигтай зовлонтой үед ч сэтгэлийг минь дулаацуулах энэ л цамц, ороолт хоёр.

Ээжийн үнэртэй цамц, ороолт хоёртойгоо байхад би алзахгүй гэж боддог юм.Ээж минь тэнгэрийн холоос намайг харан хамгаалж л суугаа даа.

**1.Хүү хэнтэйгээ амьдардаг байсан бэ? / 1 оноо /**

A. Ээж B. Эмээ C. Аав D. Аав ээж

**2.Хүүгийн ээж яагаад эцэг эхийн хуралд очдоггүй байсан бэ? / 1 оноо /**

A.Мэдээгүй учраас B.Завгүй ажилладаг учраас

C. Хүсээгүй учраас D. Дээрх бүгд

**3."Борогхон" гэдэг үгийн утгад тохирох үгийг олоорой ! / 1 оноо /**

Боловсруулсан сургалтын менежер Т.Долгормаа

А. ядруухан.                    Б. Дутмагхан    В. эмзэгхэн                    С. Шавилхан

**4. Эхийн үйл явдлыг дарааллаар нь зөв байрлуулсныг олоорой. / 1 оноо /**

А. Бага насны амьдрал, төрсөн өдрийн бэлэг, ээжийн сонголт, их сургуульд сурсан.

Б. Хоёр биенээ тэжээх гэж ажилласан, ээжийн сонголт байсан, ээжээс бэлэг авсан.

В. Их сургуулийн зардал, ээжийн бэлэг, ээжээрээ бахархсан.

**5. Уриалсан өнгө аястай үгийг олоорой. /1 оноо/**

А. бахархах.                    Б. бахархана                    В. бахархаад                    С. бахархцаав

**6.Энэ эхэд аль зүйр тохирч байна вэ?**

А. Хайр нь дотроо

Б. Эхийн санаа үрд

В. Үхтэл үр харам

Хал нь гаднаа

Үрийн санаа хаданд

**7. Ээж нь яагаад их сургуульд хэдэн төгрөг зарцуулах бол гэж асуусан бэ ? / 1 оноо /**

А.Мөнгө нь хүрэхгүй бол мөнгө олох ажил хайх гэж    Б. Бэлтдсэн мөнгөө хүрэх, үгүйг мэдэх гэж

В. Зүгээр сонирхож асуусан.

**8. “Орхиж” гэдэг үгийн балархай эгшигтэй ижил үүргээр бичигдсэн үгийг олоорой.**

**/ 1 оноо /**

А.Харьж

Б. морьтой

В. Салхилж

Г. Ахиж

**9.Дараах үгнээс “ийг” залгаврыг залгах үгийг олж дугуйлаарай. / 1 оноо /**

А.санал

Б. харамч

В. ард

Г. Арга

**10. Өгүүлбэрийг холбодог холбоос үгийг олоорой. / 1 оноо /**

А.харин, учраас

Б. ба, бөгөөд

В.цаашилбал

Г. Үүнээс гадна

**ХОЁРДУГААР ХЭСЭГ: ЗАДГАЙ ДААЛГАВАР.**

**2.1 Дараах үгсийн ойролцоо утгатай үгийг олж бич. / 2 оноо /**

баясгалантай - ..... эвэршсэн .....

**2.2 Өгүүлбэрийг гүйцээж бичээрэй. / 3 оноо /**

Энэ үед дэвшин суралцах сургуулийн тухай хурал болоход ээж маань анх удаа гараа өргөн босч "....." гэж асууж билээ.

**2.3 Дараах үгсийн балархай эгшиг “и” ямар үүрэгтэйг бичээрэй. / 2 оноо /**

А. Бохир- .....

агшин - .....

Баримт - .....

үсчин - .....

**2.4 Дараах үгэнд я, е,ё,-г зөв залган бичээрэй. / 2 оноо /**

балга..

асга...

ёол..

хүлээ ...

**2.5 Хүүгийн өмнөөс ээждээ зориулж баярласнаа илэрхийлсэн захидал бичээрэй. / 5 оноо /**

/ 30 - 40 үгтэй. /

.....  
.....  
.....  
.....  
.....



БАТЛАВ.

ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ө.ЦЭВЭЭНСҮРЭН

МАТАД СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН 2023-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН  
4 ДҮГЭЭР АНГИЙН МОНГОЛ ХЭЛ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ

Сурагчийн ..... овог ..... нэр

..... он ..... сар ..... өдөр

“Б” ХУВИЛБАР

ХУГАЦАА: 40 МИН: НИЙТ 24 ОНОО

НЭГ: УНШИХ ЧАДВАРЫН ДААЛГАВАР Санамж:1.Эхийг анхааралтай давтан уншиж ойлгосны дараа даалгаврыг гүйцэтгээрэй.

2.Сонгох даалгаврын зөвхөн нэг л хувилбарыг сонгоорой.

Сонгох хариутай даалгавар бүр 1 оноотой

Эхийн хайр

Эхийн хайр Бага насны минь дутуу гацуу борогхон амьдрал минь... Ухаан орсон цагаас минь л миний дэргэд аав аа гэж дуудах хүн байсангүй. Дандаа л ээж, ээж, бас дахин ээж... Ээж ажилдаа явна. Ээж хоолоо хийнэ. Ээж гэрээ цэвэрлэнэ. Бүгдийг л ээж минь амжуулдаг байж. Харин сургуулийн биеийн тамирын арга хэмжээ, тэмцээн уралдаан, эцэг эхийн хурал болоход ээж минь ирдэггүй байлаа. Үнэндээ хоёр биенээ тэжээх гэж зүтгэж ажиллаж байсан ээжид минь сургууль дээр ирэх зав байдаггүй байлаа. Ажил .... ажил... ажил...Ийм л амьдралд өсчээ би.

15 нас хүрэх жил юм даг. Анх удаа ээжээсээ төрсөн өдрийн бэлэг авлаа. Дулаахан бор өнгийн ноосон цамц.Ээжээсээ бэлэг авна гэдэг хичнээн сайхан ч дотроо би ээжийгээ ихэд өрөвдөж байлаа. "Ээж минь цамц надад авч байхын оронд энэ мөнгөөрөө хиймэл шүдээ хийлгэхгүй дээ..." гэж бодож байв. Өөртөө биш үр хүүхдэдээ бүхнийг зориулдаг эх хүн гэдэг агуу. Гар нь хатууран эвэршээд нүүрэндээ ямар ч оо энгэсэг түрхээгүй ээж минь миний төлөө хичнээн зүтгэж ажиллаж байгааг ойлгодоггүй байж дээ.

Зургийн альбом дээрх залуу насны ээжийн минь ганган зураг үнэхээр л түүх болон үлджээ. Цав цагаан шүдээ яралзуулан инээх ээжийн минь залуу нас гангар шаазан шиг хэврэгхэн бас богинохон байж. Дэрвэлзэж явсан залуу насаа орхиж дэндүү жаахан үрийнхээ төлөө зүтгэхээр эвэршсэн гар, энгэсэггүй царайг сонгожээ ээж минь. Өөрийн эрхгүй нулимс гарч байлаа.

Удалгүй ахлах сургуулиа төгслөө. Энэ үед дэвшин суралцах сургуулийн тухай хурал болоход ээж маань анх удаа гараа өргөн босч "Их сургуульд хэдэн төгрөг зарцуулах бол..." гэж асууж билээ.Их сургуульд явах ямар ч бололцоогүйг минь мэдсээр байж, яагаад... гэж бодон гайхан ээж рүүгээ харахад ээж минь гэртээ хариад надад хадгаламжийн дэвтэр үзүүллээ.

Их сургуульд сурах 4 жилийн зардлыг ээж минь цуглуулсан байлаа. Өөрийгөө гаргуунд нь хаян байж ажиллаж байсан ээжээрээ бахархаад баршгүй.Нутгаасаа хол сургуульд явах үед ээж минь нүд дүүрэн нулимстай инээвхийлэн "Миний хүү хичээгээрэй. Ээжийнх нь санаа одоо л нэг амарч байна. Энэ ороолтыг ээжийгээ санасан үедээ зүүгээрэй" хэмээн хэзээ ч юм бас л гараараа нэхсэн улаан ноосон хүзүүний ороолт надад зүүлгэж билээ. Их сургуулийн 4 жилийг ээжийнхээ өгсөн бор ноосон цамц, улаан ороолтоор чимэн амжилттай төгсөв. Амьдралын баяр баясгалантай үед ч, уйтгар гунигтай зовлонтой үед ч сэтгэлийг минь дулаацуулах энэ л цамц, ороолт хоёр.

Ээжийн үнэртэй цамц, ороолт хоёртойгоо байхад би алзахгүй гэж боддог юм.Ээж минь тэнгэрийн холоос намайг харан хамгаалж л суугаа даа.

**1.Хүүг 15 нас хүртэл ямар үйл явдал болсон бэ? / 1 оноо /**

A. Ахлах сургуулиа төгссөн.

B. Анх удаа ээжээсээ бэлэг авсан.

C. Их сургуульд элссэн.

**2. Ээж үрийнхээ төлөө юуг сонгосон бэ? / 1 оноо /**

A.Энгэсэг гүү сайхныг

B.Гоё сайхан хувцас

C. Энгэсэггүй царайг

D. Уранхай цоорхой хувцас.

Боловсруулсан сургалтын менежер Т.Долгормаа

**3."Эвэршээд" гэдэг үгийн утгад тохирох үгийг олоорой ! / 1 оноо /**

А. Зөөлөн.                      Б. Хатуурсан    В. Сайртаад                      С. Туураад

**4. Эхийн үйл явдлыг дарааллаар нь зөв байрлуулсныг олоорой. / 1 оноо /**

А. Хоёр биенээ тэжээх гэж ажилласан, ээжийн сонголт байсан, ээжээс бэлэг авсан.

Б. Их сургуулийн зардал, ээжийн бэлэг, ээжээрээ бахархсан.

В. Бага насны амьдрал, төрсөн өдрийн бэлэг, ээжийн сонголт, их сургуульд сурсан.

**5. Уриалсан өнгө аястай үгийг олоорой. /1 оноо/**

А.хичээгээрэй    Б. хичээцгээе                      В. хичээдэг                      С.хичээсэн

**6.Энэ эхэд аль зүйр тохирч байна вэ?**

А. Ажил үнэртэй бол                      Б. Ажилд алгаан холговол                      В. Ажлаас айдаггүй хүн  
Ашиг ихтэй                      Ард нь амаан тосдоно.                      Өлсөхөөс айдаггүй

**7. Хүүгийн нулимс яагаад гарсан бэ ? / 1 оноо /**

А.Баярлаад                      Б. Гуниглаад                      В. Ээжийгээ өрөвдөөд.

**8. "Сонгожээ гэдэг үгийн балархай эгшигтэй ижил үүргээр бичигдсэн үгийг олоорой.**

**/ 1 оноо /**

А.ойлгожээ                      Б. гунигтай                      В. санасан                      Г. сэтгэлийг

**9.Дараах үгнээс "ыг" залгаврыг залгах үгийг олж дугуйлаарай. / 1 оноо /**

А.өрөм                      Б. санал                      В. эмч                      Г. хонь

**10. Эхийн бүтцийг холбохдоо хэрэглэдэг үгүүдийг олоорой. / 1 оноо /**

А. ба                      Б.бөгөөд                      В.харин                      Г. буюу

**ХОЁРДУГААР ХЭСЭГ: ЗАДГАЙ ДААЛГАВАР.**

**2.1 Дараах үгсийн ойролцоо утгатай үгийг олж бич. / 2 оноо /**

Хажууд - ..... алзахгүй-.....

**2.2 Өгүүлбэрийг гүйцээж бичээрэй. / 3 оноо /**

Нутгаасаа хол сургуульд явах үед ээж минь нүд дүүрэн нулимстай инээвхийлэн  
"....." нэг амарч байна.

**2.3 Дараах үгсийн балархай эгшиг "и" ямар үүрэгтэйг бичээрэй. / 2 оноо /**

А. Сорил - ..... ижил- .....  
Бодис - ..... малчин - .....

**2.4 Дараах үгэнд я, е,ё,-г зөв залган бичээрэй. / 2 оноо /**

олго..                      тарь...                      оё..                      тараа ...

**2.5 Хүүгийн өмнөөс ээждээ зориулж баярласнаа илэрхийлсэн захидал бичээрэй. / 5 оноо /**

**/ 30 - 40 үгтэй. /**

.....  
.....  
.....  
.....  
.....  
.....









4 ДҮГЭЭР АНГИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДВИЙН ТҮЛХҮҮР

Даалгаврын дугаар	Даалгаврын хэлбэр	Танин мэдэхүйн түвшин	Оноо	Зөв хариулт		Онооны тайлбар
				А хувилбар	Б.хувилбар	
1	унших	Мэдлэг ойлголт	1	А	Б	Зөв сонгосон хариулт тус бүр 1 оноо
2	унших	Мэдлэг ойлголт	1	В	В	Зөв сонгосон хариулт тус бүр 1 оноо
3	бичих	Мэдлэг ойлголт	1	Б	В	Зөв сонгосон хариулт тус бүр 1 оноо
4	бичих	Мэдлэг ойлголт	1	А	В	Зөв сонгосон хариулт тус бүр 1 оноо
5	хэлзүй	Мэдлэг ойлголт	1	Г	Б	Зөв сонгосон хариулт тус бүр 1 оноо
6	унших	чадвар	1	А	Б	Зөв сонгосон хариулт тус бүр 1 оноо
7	унших	чадвар	1	Б	В	Зөв сонгосон хариулт тус бүр 1 оноо
8	бичих	чадвар	1	Г	А	Зөв сонгосон хариулт тус бүр 1 оноо
9	хэлзүй	чадвар	1	Б	Б	Зөв сонгосон хариулт тус бүр 1 оноо
10	Хэл зүй	чадвар	1	Б	В	Зөв сонгосон хариулт тус бүр 1 оноо
<b>ЗАДГАЙ ДААЛГАВАР</b>						
2.1	унших	чадвар	2	-жижигхэн, бага зэрэг, үл ялиг эдгээр үгсийн аль нэгийг бичих - хатуурах, сайртах	- дэргэд -ядрахгүй, ажирахгүй,дажгүй гэх мэт үгээс аль нэгийг сонгож бич.	Ойролцоо утгатай үг тус бүр 1 оноо
2.2	Бичих	чадвар	3	Их сургуульд хэдэн төгрөг зарцуулах бол	Миний хүү хичээгээрий. ээжийнх нь санаа одоо л	Үг тус бүр 0.5 оноо
2.3	Хэл зүй	чадвар	2	Бохир- зөөлрүүлэх	Сорил- зөөлрүүлэх	Үг тус бүр 0.5 оноо

				<ul style="list-style-type: none"> <li>- Агшин- эгшигжүүлэх</li> <li>- Баримт,- зөөлрүүлэх</li> <li>- Үсчин- эгшигжүүлэх</li> </ul>	<p>Ижил- эгшигжүүлэх</p> <p>Бодис - зөөлрүүлэх</p>	
2.4	хэлзүй	чадвар	2	Балгая, асгая, сольё, хүлээе	Олгоё, тарья, оёё, тараая	Зөв бичсэн үг тус бүр 0.5 оноо
<b>ЗАХИДАЛ БИЧИХ</b>						
2.5	Бичих	хэрэглээ	5	<ul style="list-style-type: none"> <li>- Зөв бичгийн дүрэм 1 оноо: буруу бичсэн үг бүрээс 0.1 оноо хасна.</li> <li>- Захидлын бүтэцийн дагуу, эхлэл, гол, төгсгөл хэсгийг гаргаж утгын уялдаа холбоотой бичсэн бол 4 оноо</li> <li>- Бүтцийн дагуу бичээгүй бол 3 оноо</li> <li>- Бүтцийн аль нэг хэсгийг дутуу гаргасан, утгын уялдаа холбоо тааруухан бол 2 оноо.</li> <li>- Утгын уялдаа холбоогүй, бүтцийн дагуу бичээгүй бол 1 оноо.</li> </ul>		